

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: НТАГ-2020/424/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2020 он

Захирал бөгөөд аудитын багийн ахлагч: Н.Цэрэнханд

Утас: 9990157 Цахим хаяг: Khandnorov@yahoo.com

Аудитын менежер: Д.Өлзий-Орших

Утас: 9948779 Цахим хаяг: Ulzii@gmail.com

Аудиторын туслах: Б.Баярмаа

Утас: 99020639 Цахим хаяг: Bayarmaa_0220@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.02.21 № 407
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН
ТУСЛАМЖИЙН ТӨВИЙН ДАРГА,
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
Ц.ПҮРЭВДАШ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын


хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.МӨНХ-ОЧИР



Товчилсон үгийн жагсаалт

ҮАГ	Үндэсний аудитын газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын Стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3. Менежментийн захидал.....	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	20
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	22

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Ц.Пүрэвдаш танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд НТАГ-тай байгуулсан гуравласан гэрээг үндэслэн аудит хийлээ.

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 09 дүгээр сарын 12-ноос 2020 оны 02 дугаар сарын 19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, "Цэгцтөв богд аудит" ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг "Цэгцтөв богд аудит" ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 02/31 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Мэргэжлийн болон ёс зүйн өндөр ур чадвар эзэмшсэн баг эмнэлэг хүртэлх түргэн тусламжийг цаг алдалгүй чанартай, хүртээмжтэй хүргэх явдал юм".

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийслэлийн нутаг дэвсгэрийн төвийн 6 дүүрэг болон алсын дуудлагаар хүн амд газар дээр нь болон эмнэлэг хүртэлх түргэн тусламжийн үйлчилгээг оновчтой шуурхай хүргэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2012 онд боловсруулагдсан Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, шинэчлэгдсэн стандартууд, хууль тогтоомжийн өөрчлөлтүүдтэй нийцээгүй байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Нийслэлийн түргэн тусламжийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 19 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "бага" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 8,574,782.6 мянган төгрөгөөс тооцон 171,495.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 181,310,87 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн 490,760.9 мянган төгрөгөөр буюу 5.7 хувь өссөнтэй холбоотой.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 562,693.7 мянган төгрөгөөр буюу 4,2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	14,704.40	3,861.40	(10,843.00)
Бараа материал	540,766.20	458,494.30	(82,271.90)
Үндсэн хөрөнгө	7,860,194.40	7,479,426.80	(380,767.60)
Нийт хөрөнгө	8,415,665.00	7,941,782.50	(473,882.50)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	8,415,665.00	7,941,782.50	(473,882.50)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,415,665.00	7,941,782.50	(473,882.50)

Авлага дансны үлдэгдэл буурсан нь 2007 онд үүссэн шүүхийн шатанд байсан 10,000.0 мянган төгрөгийн авлагыг шүүхийн шийдвэрийн дагуу данснаас хассанаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь эмнэлгийн хэрэгсэл 24,603.9 мянган төгрөг, аж ахуйн материал 75,954.3 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 9,196.4 мянган төгрөг нийт 106,756.3 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгаснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй, хэрэгцээ шаардлага хангахгүй бараа материал байхгүй ба яаралтай тусламжийн стандартаар байвал зохих /биксэн дэх/ эмийн үлдэгдэл тогтмол шинэчлэгдэж хэрэглэж байдаг, хэрэгцээнээс илүү худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь үнэ төлбөргүй шилжиж ирсэн 503,944,0 мянган төгрөгийн хөрөнгө Үүнд:

Нийслэлийн эрүүл мэндийн газар, Нийслэлийн өмч ашиглалт удирдлагын газрын захиалгаар зарлагдсан нээлттэй тендер шалгаруулалтаар гүйцэтгэгч "НҮСО" ХХК-аас нэг бүр нь 119,452.0 мянган төгрөгийн үнэ бүхий багаж хэрэгслэлээр тоноглогдсон түргэн тусламжийн автомашин 3 ширхэг нийт 358,356.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн

яамнаас “Улаанбаатар хотод байрлалтай эрүүл мэндийн байгууллагуудыг эмнэлгийн түргэн тусламжийн автомашинаар хангах төслийн гэрээний дагуу нийлүүлэгдсэн нэг бүр нь 24,968.0 мянган төгрөгийн үнэ бүхий түргэн тусламжийн автомашин 3 ширхэг нийт 74,904.0 мянган төгрөг, Нийслэлийн эрүүл мэндийн газраас нийлүүлэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж 35,684.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн яамнаас эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж төсөл, арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдсэн зөөврийн ЭХО аппарат 35,000.0 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 58,749.6 мянган төгрөг нийт 562,693.7 мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгдэж, үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 20,000.0 мянган төгрөг, акталж устгасан 265,005.3 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсанаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 473,882.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Нийслэлийн түргэн тусламжийн төв тайлант онд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө батлагдаагүй боловч гүйцэтгэлээр 15,657.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Тус төвийн төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан улсын төсвөөс 8,082,003.3 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авахаар төсөв батлагдсаныг бүрэн авч, үйл ажиллагааны урсгал зардалд 8,070,752.0 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 11,251.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8,070,752.0 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь ашиглалтын зардал 3,900.8 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 2,156.2 мянган төгрөг, томилолт, зочны зардал 1,631.0 мянган төгрөг бусад зардал 5,385.6 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нэмэлт төсөв: Засаг даргын нөөц хөрөнгөнөөс улсын баяр наадмын зардалд 4,200.0 мянга, Нийслэлийн эрүүл мэндийн газраас Улсын их баяр наадмын зардалд 1,397.0 мянга, марфон гүйлтийн зардалд 1,000.0 мянга, байгууллагын шагнал урамшуулалд 1,000.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 8,060.0 мянга, нийт 15,657.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Нэмэлт төсвийн зардлын гүйцэтгэлийн дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.6-д дэлгэрэнгүй харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 19 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 24 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 14,330.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 11,898.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2,431.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

Аудитаар дараах 11,898.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

Өөрийн хүсэлтээр тэтгэвэр тогтоолгож төрийн албанаас чөлөөлөгдөн үргэлжлүүлэн гэрээгээр ажиллаж байгаа 14 ахмад настанд өмнө нь авч байсан цалин болон төрийн албан хаагчдын нэмэгдэл хөлс 11,898.9 мянган төгрөг олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4 "үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс тус тус бүрдэнэ" заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн

Аудитаар илэрсэн 2,431.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татах чухал асуудал гараагүй болно.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 20 мэдээллийг хугацаанд нь байршуулсан бөгөөд хугацаа хоцроосон болон байршуулаагүй мэдээлэл байхгүй.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 51,500.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 6 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2019 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит




НИЙСЛЭЛИЙН
ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ

14210 Улс анхиагч хот, Сүхбаатар дүүрэг,
1 дүгээр хороо, Чин ван Т-ийг даршвент гудамж,
Утас/Факс: (976-11) 32 18 11, И-мэйл: нтсд@103.ub.gov.mn,
Вэбсайт: www.103.ub.gov.mn

2020.03.06 № 02/31
таний _____ -ийн № _____ Т

ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-Д

Тус төвд аудитын хяналт, шалгалтаар хийгдсэн асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, цаашид уг асуудлыг барагдуулан хэрэгжүүлж ажиллах болно.

ЗАХИРАЛ  ПҮРЭВДАШ

• 314070168

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. **Балансын данстай холбоотой асуудал**

1.1.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн байгууллагын онцлог, үйл ажиллагаатай уялдаж байгаа хэдий ч Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомж, заавар, журмын дагуу шинэчлэгдээгүй байна. Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" заалтыг зөрчсөн.

1.1.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан заавар, журам зөрчигдөх, тайлан буруу илэрхийлэгдэх

1.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хууль тогтоомж, стандарт, дүрэм, журамд нийцүүлэн шинэчилж байх.

1.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитын байгууллагаар хийлгэж байгаа болно

1.2.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглагдаж байгаа 284 нэр төрлийн үндсэн хөрөнгө байгаа нь УСНББОУС-17-ийн 55-д "...хөрөнгийн үнэ цэнэ нь түүний дансны үнээс илүү байх тохиолдолд ч элэгдлийн шимтгэлийг байгуулна", Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2014 оны 66 дугаар

тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4.9 "хуулийн этгээд нь ашиглалтын хугацаа дууссан, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ балансын үнээ нөхсөн, сэргээн засварлаж цаашид ашиглах боломжгүй болсон тавилга эд хогшлыг актлах тухай саналаа Өмчийн харилцааны газарт ирүүлэн хянуулж, албан тоотой зөвшөөрөл авсны үндсэн дээр тухайн хуулийн этгээдийн дарга /захирал/-ын тушаалаар данснаас хасна" заалтыг зөрчсөн.

1.2.2. Эрсдэл:

Элэгдэл тооцогдохгүй байх, санхүүгийн тайлангийн үнэлгээ, хэмжилт батламж мэдэгдэл хангагдахгүй байх

1.2.3. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлгээ хийлгэх эсэхийг шийдвэрлэх

1.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Нийслэлийн өмч ашиглалт удирдлагын газартай хамтран зөвлөмжийг стандартын дагуу хэрэгжүүлэн ажиллана.

1.3.1. Илрүүлэлт:

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн 6,623.3 мянган төгрөгийн шүүхийн шийдвэрийн 2,431.5 мянган төгрөгийг төлөөгүй, өглөг үүсгээгүй байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 "Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7, Иргэний хуулийн 498.2 заасны дагуу захиргааны байгууллагын гаргасан алдааны улмаас учруулсан хохирлыг төр хариуцна" гэж заасныг зөрчсөн.

1.3.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдахгүй байх

1.3.3 Өгсөн зөвлөмж:

Шүүхийн шийдвэрийг биелүүлж авлага, өглөг үүсгэж бүртгэлд тусгах

1.1. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Нэмэгдэл хөлс олгох үндэслэл, ажлын товч агуулгыг тодорхойлоогүй байгаа нь. Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын "нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас" маягтыг хөтлөх заалтыг зөрчсөн.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, санхүүгийн тайлангийн Үнэн зөв байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх

1.3 Өгсөн зөвлөмж:

Илүү цагаар ажиллуулах ажлын агуулга, үндэслэлийг тодорхойлох маягыг хөтөлж Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид бэлэн байдлыг ханган ажиллах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 5 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

Хянасан:

Санхүүгийн аудитын хэлтсийн дарга бөгөөд
аудитын менежер

Аудитын менежер

Бэлтгэсэн:

"Цэгцтөв богд аудит" ХХК-ийн захирал,

аудитын багийн ахлагч



Ц.Бат-Өлзий

Д.Отгонбаяр



Н.Цэрэнханд

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>555,470,602.68</u>	<u>462,355,715.52</u>
33	АВЛАГА	14,704,422.39	3,861,422.39
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,569,882.39	1,226,882.39
335	Бусад авлага	13,134,740.00	2,634,740.00
3351	Байгууллагаас авах авлага	3,134,740.00	2,634,740.00
35	БАРАА МАТЕРИАЛ	540,766,180.29	458,494,293.13
351	Түүхий эд материал	174,837,760.00	156,527,002.40
35130	Эм боох материал	174,837,760.00	156,527,002.40
354	Хангамжийн материал	365,928,420.29	301,967,290.73
35410	Бичиг хэргийн материал	3,682,133.00	2,490,145.00
35420	Аж ахуйн материал	277,104,020.79	248,130,422.73
35430	Сэлбэг хэрэгсэл	50,679,386.50	50,766,328.00
35440	Түлш, шатах тослох материал	34,462,880.00	580,395.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,860,194,409.26</u>	<u>7,479,426,804.33</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,860,194,409.26	7,479,426,804.33
392	Биет хөрөнгө	7,351,935,234.26	6,980,094,129.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,776,170,946.30	5,776,170,946.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-149,603,354.76
39203	Авто-тээврийн хэрэгсэл	4,638,656,549.24	4,829,698,172.24
39204	Хуримтлагдсан элэгдэл	-3,552,082,182.33	-3,896,279,171.57
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,019,981,910.74	2,106,004,161.83
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,617,024,129.02	-1,764,339,431.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	185,616,443.63	186,240,947.63
39208	Хуримтлагдсан элэгдэл	-99,384,304.30	-107,798,140.96
393	Биет бус хөрөнгө	508,259,175.00	499,332,675.00
39301	Програм хангамж	46,432,500.00	46,432,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,492,625.00	-12,419,125.00
39303	Бусад биет бус хөрөнгө	465,319,300.00	465,319,300.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>8,415,665,011.94</u>	<u>7,941,782,519.85</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>8,415,665,011.94</u>	<u>7,941,782,519.85</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	8,415,665,011.94	7,941,782,519.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,269,530,183.95	4,269,530,183.95
51101	Өмч: - төрийн	4,269,530,183.95	4,269,530,183.95
512	Хуримтлагдсан үр дүн	872,204,882.18	399,432,479.05
51210	Өмнөх үеийн үр дүн	872,204,882.18	873,314,971.14
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-473,882,492.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,273,929,945.81	3,272,819,856.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>8,415,665,011.94</u>	<u>7,941,782,519.85</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,239,235,752.41	8,604,499,595.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,802,183,552.41	506,829,195.50
120	Нийтлэг татварын бус орлого	5,884,363.60	2,895,072.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,884,363.60	2,895,072.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,884,363.60	2,895,072.50
122	Тусламжийн орлого	2,796,299,188.81	503,944,123.00
122001	Хандив тусламж /дотоод/	2,796,299,188.81	503,944,123.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,409,760,200.00	8,097,660,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,409,760,200.00	8,082,003,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,409,760,200.00	8,082,003,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,292,000.00	15,657,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,100,000.00	4,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	3,397,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,192,000.00	8,060,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,574,782,615.18	9,067,788,575.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,574,782,615.18	9,067,788,575.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,342,824,714.93	9,048,417,286.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,957,309,944.35	5,693,452,782.50
210101	Үндсэн цалин	2,728,827,302.35	3,060,464,654.50
210102	Нэмэгдэл	1,614,912,192.00	1,863,321,595.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	337,001,550.00	467,185,440.00
210104	Урамшуулал	276,568,900.00	302,481,093.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	592,050,319.23	710,470,827.00
210201	Тэтгэврийн даатгал	397,688,434.00	483,932,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	49,586,688.23	56,933,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	39,290,117.00	45,105,104.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9,568,282.00	10,652,744.00
210205	Эрүүл мэндийн даатгал	95,916,798.00	113,847,679.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,544,493.00	133,459,489.00
210301	Гэрэл, цахилгаан	59,267,732.00	62,117,052.00
210302	Түлш, халаалт	53,876,832.00	46,470,672.00
210303	Цэвэр, бохир ус	15,192,757.00	18,128,593.00
210304	Байрны түрээс	2,207,172.00	6,743,172.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,046,231,913.89	1,196,431,787.96
210401	Бичиг хэрэг	6,769,817.00	8,459,498.00

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	943,492,916.00	965,741,093.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,586,085.00	24,911,940.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	54,737,615.01	90,564,651.46
210408	Бараа материал акталсны зардал	24,645,480.88	106,754,605.50
2105	Нормативт зардал	140,377,477.88	180,417,250.33
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	140,377,477.88	180,356,750.23
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		60500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,465,232.00	35,345,027.00
210604	Урсгал засвар	26,465,232.00	35,345,027.00
2107	Томилолт, зочны зардал	4,683,800.00	3,052,800.00
210702	Дотоод албан томилолт	4,683,800.00	3,052,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	158,065,511.00	151,919,527.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	119,099,000.00	103,259,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	7,415,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	17,976,000.00	16,784,836.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	6,314,800.00	6,060,814.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,128,600.00	2,508,000.00
210807	Газрын төлбөр	1,824,856.00	2,557,392.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	596,600.00	1,702,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,640,655.00	11,631,485.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,287,096,023.58	943,867,796.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,216,500.00	1,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,284,879,523.58	932,867,796.07
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	10,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	231,957,900.25	19,371,288.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	8,120,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	8,120,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	231,957,900.25	11,251,288.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	231,957,900.25	11,251,288.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,664,453,137.23</u>	<u>(463,288,980.23)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	989,943,397.72	10,593,511.86
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	10,593,511.86
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	989,943,397.72	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-989,943,397.72	(10,593,511.86)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>674,509,739.51</u>	<u>(473,882,492.09)</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	7,437,052,200.00	8,097,660,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,437,052,200.00	8,097,660,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,409,760,200.00	8,082,003,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,409,760,200.00	8,082,003,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,292,000.00	15,657,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,100,000.00	4,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	3,397,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,192,000.00	8,060,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	7,351,503,450.00	8,038,910,820.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,351,503,450.00	8,038,910,820.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,119,545,549.75	8,019,539,531.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,958,744,106.52	5,693,109,782.50
210101	Үндсэн цалин	2,730,261,464.52	3,072,960,882.50
210102	Нэмэгдэл	1,614,912,192.00	1,843,901,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	337,001,550.00	468,930,000.00
210104	Урамшуулал	276,568,900.00	307,317,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	592,050,319.23	710,470,827.00
210201	Тэтгэврийн даатгал	592,050,319.23	483,932,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	56,933,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	45,105,104.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	10,652,744.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	113,847,679.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,544,493.00	133,459,489.00
210301	Гэрэл, цахилгаан	59,267,732.00	62,117,052.00
210302	Түлш, халаалт	53,876,832.00	46,470,672.00
210303	Цэвэр, бохир ус	15,192,757.00	18,128,593.00
210304	Байрны түрээс	2,207,172.00	6,743,172.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,036,302,764.00	1,069,872,277.40
210401	Бичиг хэрэг	3,709,829.00	2,512,635.00
210402	Тээвэр, шатахуун	933,256,334.00	934,936,680.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,586,085.00	24,911,940.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	77,812,516.00	99,389,942.40
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,938,000.00	8,121,080.00

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	208,044,339.00	219,330,306.13
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	183,662,359.00	182,948,806.13
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	24,381,980.00	36,381,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,810,332.00	26,810,257.00
210602	Тавилга	00.00	154,000.00
210604	Урсгал засвар	14,810,332.00	26,656,257.00
2107	Томилолт, зочны зардал	4,683,800.00	3,052,800.00
210702	Дотоод албан томилолт	4,683,800.00	3,052,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	171,968,896.00	162,433,792.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	125,712,000.00	107,934,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	7,415,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	17,976,000.00	16,784,836.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	6,314,800.00	6,060,814.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,128,600.00	2,508,000.00
210807	Газрын төлбөр	1,824,856.00	2,557,392.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	596,600.00	1,702,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	16,931,040.00	17,470,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,396,500.00	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,396,500.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	231,957,900.25	19,371,288.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	8,120,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	8,120,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	231,957,900.25	11,251,288.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	231,957,900.25	11,251,288.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>85,548,750.00</u>	<u>58,749,580.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	85,548,750.00	58,749,580.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	85,548,750.00	58,749,580.00
2200	Дотоод эх үүсвэрээр	85,548,750.00	58,749,580.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	85,548,750.00	58,749,580.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-85,548,750.00</u>	<u>-58,749,580.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	3,804,210,883.95	1,040,310,821.49	110,666,594.67	4,955,188,300.11
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	87,028,547.70	87,028,547.70
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,804,210,883.95	1,040,310,821.49	110,666,594.67	4,955,188,300.11
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	2,233,619,124.32	00.00	2,233,619,124.32
C07	Тайлант үеийн үр дүн	465,319,300.00	00.00	674,509,739.51	1,139,829,039.51
C08	2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	4,269,530,183.95	3,273,929,945.81	872,204,882.18	8,415,665,011.94
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,110,088.96	1,110,088.96
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,269,530,183.95	3,273,929,945.81	873,314,971.14	8,416,775,100.90
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,110,088.96	00.00	-1,110,088.96
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-473,882,492.09	-473,882,492.09
D09	2019 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	4,269,530,183.95	3,272,819,856.85	399,432,479.05	7,941,782,519.85

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Дүн	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,082,003,300.00	8,070,752,011.03	11,251,288.97	99.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,082,003,300.00	8,070,752,011.03	11,251,288.97	99.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,073,883,300.00	8,062,632,011.03	11,251,288.97	99.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,693,318,700.00	5,693,109,782.50	208,917.50	100.00
210101	Үндсэн цалин	3,073,169,800.00	3,072,960,882.50	208,917.50	99.99
210102	Нэмэгдэл	1,843,901,900.00	1,843,901,900.00	-	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	468,930,000.00	468,930,000.00	-	100.00
210104	Урамшуулал	307,317,000.00	307,317,000.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	711,664,800.00	710,470,827.00	1,193,973.00	99.83
210201	Тэтгэврийн даатгал	483,932,100.00	483,932,100.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	56,933,200.00	56,933,200.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	45,546,500.00	45,105,104.00	441,396.00	99.03
210204	Ажилгүйдлийн даатгал	11,386,600.00	10,652,744.00	733,856.00	93.56
210205	Эрүүл мэндийн даатгал	113,866,400.00	113,847,679.00	18,721.00	99.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132,824,300.00	128,923,489.00	3,900,811.00	97.06
210301	Гэрэл, цахилгаан	62,117,100.00	62,117,052.00	48.00	100.00
210302	Түлш, халаалт	47,550,100.00	46,470,672.00	1,079,428.00	97.73
210303	Цэвэр, бохир ус	19,925,700.00	18,128,593.00	1,797,107.00	90.98
210304	Байрны түрээс	3,231,400.00	2,207,172.00	1,024,228.00	68.30
2104	Хангамж, бараа материалын зардал	1,079,248,400.00	1,077,092,177.40	2,156,222.60	99.80
210401	Бичиг хэрэг	2,514,600.00	2,512,635.00	1,965.00	99.92
210402	Тээвэр, шатахуун	934,436,700.00	934,436,680.00	20.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,023,700.00	24,911,940.00	2,111,760.00	92.19
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	99,402,200.00	99,389,942.40	12,257.60	99.99
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,871,200.00	15,840,980.00	30,220.00	99.81
2105	Нормативт зардал	219,330,900.00	219,330,306.13	593.87	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	182,948,900.00	182,948,806.13	93.87	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	36,382,000.00	36,381,500.00	500.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	77,889,500.00	77,839,937.00	49,563.00	99.94
210601	Багаж, техник, хэрэгсэл	39,112,900.00	39,074,880.00	38,020.00	99.90
210602	Тавилга	12,120,000.00	12,108,800.00	11,200.00	99.91
210604	Урсгал засвар	26,656,600.00	26,656,257.00	343.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	4,683,800.00	3,052,800.00	1,631,000.00	65.18
210702	Дотоод албан томилолт	4,683,800.00	3,052,800.00	1,631,000.00	65.18

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,467,700.00	51,475,192.00	1,992,508.00	96.27
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,485,000.00	5,485,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	17,976,800.00	16,784,836.00	1,191,964.00	93.37
210804	Тээврийн хэрэгслийн татвар	6,551,200.00	6,060,814.00	490,386.00	92.51
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,508,000.00	2,508,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	2,557,400.00	2,557,392.00	8.00	100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	613,800.00	608,400.00	5,400.00	99.12
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	17,775,500.00	17,470,750.00	304,750.00	98.29
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	101,455,200.00	101,337,500.00	117,700.00	99.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	101,455,200.00	101,337,500.00	117,700.00	99.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,120,000.00	8,120,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,082,003,300.00	8,070,752,011.03	11,251,288.97	99.86
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,082,003,300.00	8,070,752,011.03	11,251,288.97	99.86
131001	Улсын төсвөөс санхүүжих	8,082,003,300.00	8,070,752,011.03	11,251,288.97	99.86
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	406.00	445.00	(39.00)	109.61
620001	Удирдах ажилтан	6.00	6.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	258.00	258.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	142.00	181.00	(39.00)	127.46
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	406.00	406.00	-	100.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	222	223	(1.00)	100.45
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	184	183	1	99.46

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	27,292,000.00	15,657,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	27,292,000.00	15,657,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,100,000.00	15,657,100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,000,000.00	
210104	Урамшуулал	15,000,000.00	
2104	Хангамж бараа материалын зардал	195,000.00	
210402	Тээвэр шатахуун	195,000.00	
2105	Нормативт зардал	408,500.00	
210501	Эм,бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл	408,500.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		5,036,000.00
	Түлш, халаалт		500,000.00
210304	Байрны түрээс		4,536,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,100,000.00	9,621,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,615,000.00	6,597,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	1,930,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		1,094,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	396,500.00	1,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	396,500.00	1,000,000.00
2133	Олгосон санхүүжилт шилжүүлэг	6,192,000.00	
213503	Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,192,000.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	27,292,000.00	15,657,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,292,000.00	15,657,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,100,000.00	4,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	3,397,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,192,000.00	8,060,000.00
131106	Төсвийн урамшуулал		
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		